



АУДИТЫН КОД: САГ-2018/18/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Жавхлан

Утас: 261628 Цахим хаяг: jawhlang@audit.gov.mn

Аудитор Г.Мөнхчимэг, Х.Ундрага

Утас: 261628 Цахим хаяг: munkhchimegg@audit.gov.mn

Агуулга

1	Аудитын хураангуй тайлан	2
2	Аудитын гэрчилгээ	5
3	Аудитын тайлан.....	7
3.1	Оршил.....	7
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	7
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	8
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
3.5	Дотоод аудит.....	10
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
3.7	Шилэн дансны мэдээлэл.....	11
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	12
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	12
3.9.1	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар.....	12
3.9.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	13
	Урьдчилж гарсан зардлын талаар	13
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	13
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд.....	13
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	14
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	14
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	14
4	Менежментийн захидал	15
4.2	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлагналын талаар.....	17
5	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	19
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	19
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	20
5.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	21
5.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	22
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	23
5.6	Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	25
6	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	28
6.1	Албан шаардлага.....	35

1 Аудитын хураангуй тайлан

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	САГ-2018/18/СТА-ТЕЗ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Санхүүгийн аудитын газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан	Ахлах аудитор Г.Жавхлан Аудитор Г.Мөнхчимэг, Х.Ундрага
Аудитын нэр:	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит		

Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудит хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	1	1				1			
2	Цаг уур, орчны шинжилгээний газар	1	1				1			
3	Байгаль орчин, уур амьсгалын сан	1	1				1			
4	Төрийн өмчит аж ахуйн нэгж	3	2	1			2			
5	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд	88	67	8	13		64	2	1	
Нийт дүн		94	72	9	13		69	2	1	

Гурав. Аудитын үр дүн

3.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

		Алдаа, зөрчлийн		Зөвлөмж		Төлбөрийн акт		Албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	5	156.3	2	137.7			3	18.6
2	Цаг уур, орчны шинжилгээний газар	40	395.6	21	280.5	8	11.1	11	94.3
3	Байгаль орчин, уур амьсгалын сан	2	27.7	2	27.7				
4	Төрийн өмчит аж ахуйн нэгж	4	343.4	3	331.7			1	11.7
5	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд	58	505.0	45	309.5	6	6.6	7	188.9
Дүн		109	1,418.3	73	1,087.1	14	17.7	22	313.5

3.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлэн харуулбал:

Алдаа, зөрчилтэй асуудал 1.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 94 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Тус яамны харьяа 72 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт өгч, 13 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 9 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,614.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсний 17.7 сая төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт, 227.7 сая төгрөгийн зөрчилд 21 албан шаардлага, 3,484.5 сая төгрөгийн 105 алдааг аудитын явцад залруулж 884.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах талаар 71 зөвлөмж өгсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн захирагчдын санхүүгийн тайланд тавих дотоод хяналтыг сайжруулж, аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг биелүүлэх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

Алдаа, зөрчилтэй асуудал 2.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа Баянхонгор аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, Ховд аймгийн Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргааны санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-т Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, аудитад нөлөөлөхийг оролдсон, санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан,

гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

Алдаа, зөрчилтэй асуудал 3.

Ойн ангийн санхүүгийн тайланг нэгтгэхдээ 26.8 сая төгрөгийн өр төлбөрийг бууруулж тайлагнасан, 85.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр төлөвлөж тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын үлдэгдлийг тоолж баталгаажуулах, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах талаар албан шаардлага өгөв.

Алдаа, зөрчилтэй асуудал 4.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй 8,729.8 сая төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад 2,311.0 сая төгрөгөөр өссөн байна. Үлдэгдлийн 4.7 хувь буюу 202.8 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Мөн нийт үлдэгдлээс өмнөх онуудад үүссэн 5,767.8 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлын холбогдох тооцоог хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилж гарсан зардлын үлдэгдлийг тооцоо нийлэх, ажил гүйцэтгэх гэрээг дүгнэх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

Аудитын санал дүгнэлтийн үндэслэл:

3.3 Зөрчилгүй санал дүгнэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Зэсгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД
Н.ЦЭРЭНБАТ ТАНАА

2018.04.25 № 1032
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

3. Аудитын тайлан

3.1 Оршил

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (цаашид УСНББОУС гэх), түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 04 дүгээр сарын 05-наас 2018 оны 04 дүгээр сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 04 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж,

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан, аудитор Г.Мөнхчимэг, гэрээт аудитор Х.Ундрага нар хариуцаж хэрэгжүүлэв.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01/2129 дугаар албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дор дурдсан асуудлуудын бодлого төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын бодлого, стратегийг улс орны эдийн засаг, төсөв, санхүүгийн нөөц, олон улсын хамтын ажиллагааны бодлоготой уялдуулан төлөвлөж хэрэгжүүлэх, энэ чиглэлд Засгийн газрын манлайллыг хангах;
- Байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийг дэмжих, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээрх хувийн хэвшил, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн үүсгэл санаачилга, хамтын ажиллагааг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааг бодлогоор уялдуулан чиглүүлэх;
- Байгаль орчны төлөв байдал, хувьсал өөрчлөлтийн чиг хандлагыг судлан шинжлэх, байгаль орчныг хамгаалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалахтай холбогдуулан үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээнд шинжлэх ухааны ололт, ногоон технологи нэвтрүүлэхэд урамшууллын болон зохицуулалтын хөшүүрэг ашиглах.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 7 арга хэмжээ төлөвлөн ажилласан байна.

Хүснэгт №1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаархи чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтүүдийн биелэлт.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2017 оны зорилтот түвшин	Биелэлт	Хувь
1	Ойжуулалт				
	1.1	Экологийн ач холбогдол бүхий газрыг ойжуулах, ойн зурвас байгуулах /мянган га/	1.1	3.6	327.3
	1.2	Ойн хөнөөлт шавж, өвчний тархалт, голомт, хөнөөлийн талаархи судалгаа хийж, хөнөөлийг хязгаарлах тэмцлийн ажил гүйцэтгэх /мянган га/	150	171.8	114.5
	1.3	Ойн нөөцийн судалгаа, менежментийн судалгаа, ой зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэж, ойн менежментийг сайжруулах /мянган га/	1100	1100	100

**Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**

	1.4	Ойн төлөв байдлыг сайжруулан ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээ хийх /мянган га/	35	34	97.1
	1.5	Ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах /10 метрийн өргөн зурвас шинээр байгуулах, арчлах/км-ээр/	500	600.1	120.0
Усны нөөц, нуур, гол мөрний менежмент					
2	2.1	Гидрогеологийн зураглал, ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийн хайгуул судалгааны ажлын тоо	1	1	100
	2.2	Бороо, цасны ус хуримтлуулах хөв, цөөрмийн тоо	3	4	133.3
	2.3	Хашиж хамгаалах булаг шандны тоо	100	132	132.0
Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт					
3	3.1	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх /мянган га/	600	754.8	125.8
Ус, цаг уур, орчны шинжилгээ					
4	4.1	Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр ашиг /хувиар/	65	66.9	102.9
	4.2	Цаг агаарын хоногийн урьдчилсан мэдээний таарц /хувиар/	91.8	92.4	100.7
	4.3	Цаг агаарын аюултай үзэгдлийн онц /хувиар/	91	92.7	101.9
Хүрээлэн байгаа орчны бодлого, удирдлага, судалгаа шинжилгээ					
5	5.1	Байгаль орчныг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	Төлөвлөсөн хугацаанд эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар, хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулсан.	-
	5.2	Байгаль орчны төлөв байдлын тайлан боловсруулах, тайлагнах, хэвлэх, мэдээлэх /тоогоор/	1	1	100
	5.3	Ховор, нэн ховор болон ашиглалтад өртөмхий амьтан, ургамлын нөөц, тоо толгой, тархцын судалгаа хийх, амьдрах орчныг хамгаалах /амьтан, ургамлын зүйлийн тоо/	3	3	100
Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт					
6	6.1	Агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоож, гэр хорооллын галлагаанаас үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулах /хувиар/	10	3-5	
Аялал жуулчлал					
7	7.1	Жилд хүлээн авах гадаадын жуулчны тоо /мянган хүн/	500	469.3	93.9

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын 2017 оны тайлан

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Байгаль орчин, аялал жуулчлалын яамны зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 6 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 14 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа.

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2016 онд боловсруулж баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дараах чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна гэж үзлээ.Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал;
- Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал;
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагаатай холбоотой бодлого зэрэг болно.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэсэн байна.

3.5 Дотоод аудит

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод аудитыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөтэй” гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар харьяа байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх чиг үүргийг гүйцэтгэж байна.

Хүснэгт № 2. Дотоод аудитын ажлын зарим үзүүлэлтүүд

№	ҮЗҮҮЛЭЛТ		ДҮН
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо		20
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо		20
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо		20
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо	18
		Дүн (сая.төг)	406.2
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо	18
		Дүн (сая.төг)	406.2

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын 2017 оны тайлан

Яамны харьяа агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудитыг цаг тухайд нь хийж зөрчил дахин давтан гаргахгүй байхад анхаарч ажилласны дүнд зөвлөмжийн биелэлт 100 хувь байна.

Энэ нь дотоод аудитын ажлын үр дүн бөгөөд системийн хэмжээгээр эрсдэл бага, дотоод хяналт үр нөлөөтэйг харуулж байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2017 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Дээрх хуулиар Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 68.933.1 сая төгрөг, үүнээс урсгал зардалд 55,917.7 сая төгрөг, хөрөнгийн зардалд 13,015.4 сая төгрөгийг баталсан байна.

Төсөвт зардлын гүйцэтгэл нийт дүнгээрээ 95.3 хувь буюу 65,689.9 сая төгрөг байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас төсөвт зардлын эдийн засгийн ангиллаар төсөв хэтрээгүй байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Байгууллагын цахим хуудас “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.Үүнд:

- Дараа жилийн төсвийн төсөл (бүтэн жилээр)
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (бүтэн жилээр, хагас жилээр, улирал бүр, сар бүр)
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (тухай бүр)
- Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (бүтэн жилээр, хагас жилээр)
- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (бүтэн жилээр, хагас жилээр)
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (тухай бүр)
- Санхүүгийн тайлан (бүтэн жилээр, хагас жилээр)
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (бүтэн жилээр)
- Байгууллагын батлагдсан төсөв (бүтэн жилээр)

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 14 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

3.9.1 Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар

Санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 94 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Тус яамны харьяа 72 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт өгч, 13 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 9 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,614.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсний 17.7 сая төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт, 227.7 сая төгрөгийн зөрчилд 21 албан шаардлага, 3,484.5 сая төгрөгийн 105 алдааг аудитын явцад залруулж 884.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах талаар 71 зөвлөмж өгсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн захирагчдын санхүүгийн тайланд тавих дотоод хяналтыг сайжруулж, аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг биелүүлэх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа Баянхонгор аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газрын санхүүгийн тайланд

“Хязгаарлалттай”, Ховд аймгийн Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргааны санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-т Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, аудитад нөлөөлөхийг оролдсон, санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

3.9.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Ойн ангийн санхүүгийн тайланг нэгтгэхдээ 26.8 сая төгрөгийн өр төлбөрийг бууруулж тайлагнасан, 85.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр төлөвлөж тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын үлдэгдлийг тоолж баталгаажуулах, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах талаар албан шаардлага өгөв.

Урьдчилж гарсан зардлын талаар

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй 8,729.8 сая төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад 2,311.0 сая төгрөгөөр өссөн байна. Үлдэгдлийн 4.7 хувь буюу 202.8 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Мөн нийт үлдэгдлээс өмнөх онуудад үүссэн 5,767.8 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлын холбогдох тооцоог хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилж гарсан зардлын үлдэгдлийг тооцоо нийлэх, ажил гүйцэтгэх гэрээг дүгнэх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

- Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй 8,729.8 сая төгрөг нь өмнөх онтой харьцуулахад 2,311.0 сая төгрөгөөр өссөн,
- Батлагдсан төсвийг нийт дүгээр нь хэтрүүлээгүй боловч 549.6 сая төгрөгөөр зардлын ангиллыг хэтрүүлэн зарцуулсан байна.

3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд 2018 оны завсрын аудитаар авлага, өглөгийн данс, урьдчилж гарсан зардлын дансны тайлант хугацаан дахь хүлээн зөвшөөрөлтөд нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар системийн хэмжээнд нийт 4,902.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитаар нягтлан бодох бүртгэлийн 3,484.5 сая төгрөгийн алдааг залруулж, 17.7 сая төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт тогтоож, 313.5 сая төгрөгийн зөрчилд 22 албан шаардлага өгч, 1,087.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 73 зөвлөмж хүргүүлээ.

3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Үндэсний аудитын газраас Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 95 хувьтай байна.

Энэ зөвлөмжийн хэрэгжилтэд Байгаль орчны, аялал жуулчлалын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж ажилласан байна.

Зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 10/11 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурийг тооцохдоо 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 73,913.6 сая төгрөг бөгөөд түүний 2 хувиар буюу 1,478.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Иймд дээр дурдсан алдаа, зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж **“Зөрчилгүй”** санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

4. Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

4.1 Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 94 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Тус яамны харьяа 72 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт өгч, 13 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 9 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна.

